



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/01

Хархорин сум

Цэргийн бүртгэл явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын 2025 оны цэргийн бүртгэлийг 01 дүгээр сарын 06-наас 01 дүгээр сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд биечлэн болон цахим хэлбэрээр зохион байгуулсугай.

2.Цэргийн бүртгэл явуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Цэргийн бүртгэлийг үнэн зөв явуулахыг багийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд нь хяналт тавьж, тогтоосон хугацаанд тайлан мэдээг нэгтгэж, тайлагнахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Лхагвадулам)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.БАТ-ЭРДЭНЭ